



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 51 02, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddic.gov.mn,
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2025.02.07 № 01/313
танай 2025.02.03 -ны № 07 -Т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.НОМИНЧИМЭГ ТАНАА**

Танаас ирүүлсэн цахим орчин дахь аюулгүй байдал, хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх асуулгатай танилцаж, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын чиглэлээр хийсэн ажлын тайланг хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт ⁵ хуудастай.



Ц.БААТАРХҮҮ

1525070425

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны
өдрийн 1/38 дугаар албан бичгийн хавсралт



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
“ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ”-ЫН ЧИГЛЭЛЭЭР
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

1. Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг боловсруулан, 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Улмаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгдэж, тус хуулийн 25 дугаар зүйл /Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал/-ийг батлуулан, холбогдох сургалтыг 2024 оны 03 дугаар сард салбарын хэмжээнд зохион байгуулсан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан, хар тамхи, сэтгэхүйд нөлөөлөх эм бэлдмэл бэлтгэн боловсруулах, хэрэглэх зэрэг бүтээлийг бэлтгэн нэвтрүүлэхийг хориглосон. Үүнтэй холбогдуулан “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага MNS 6587:2016 стандарт”-ыг шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжилзүйн газрын даргын 2020 оны С/40 тушаалаар /MNS 6587:2020/ батлуулсан. Тус стандартыг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч болон тус үйлчилгээг эрхлэх хүсэлт гаргасан этгээдэд мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, телевизээр нэвтрүүлж байгаа “+18” контентод Харилцаа холбооны зохицуулах хорооноос байнгын хяналт тавьж ажиллаж байна..

“Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг баримталж, “Хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлого, ёс зүйн протокол” боловсруулж мөрдөх чиглэлээр 2020 оны “Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл” А/68 дугаар тушаалыг батлан, салбарын хэмжээнд хэрэгжүүлж байна.

“Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бүс зөвлөлийн ажиллах журам” болон “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төслийг Хууль зүй дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулж, олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг аливаа эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор эцэг, эх, асран хамгаалагч руугаа 2 минут үнэгүй ярих боломжтой “Итгэлтэй утас” үйлчилгээг 2022 оноос хойш ажиллуулж, нийт 457 буюу дотуур байранд 19, эмнэлэг, авто тээврийн үндэсний төвд 25, нийслэлд 121, орон нутагт 292-ийг байгуулан ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж байна.

Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, яаралтай үед шуурхай арга хэмжээг авах зорилгоор хүүхдэд олгож байгаа үүрэн холбооны операторуудын дугаарыг

заавал эцэг, эхийн мэдээллийн хамт бүртгэх ажлыг эхлүүлсэн ба тус бүртгэл 85%-тай явж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-Mongolia/-д хүүхэд хамгааллын “EKids” цонх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан яриаг бичвэр болгох технологийг “Чимэгэ” системтэй хамтран, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яамтай хамтран тус тус нэвтрүүлсэн.

2. Монгол Улсад ашиглагдаж буй цахим платформ (facebook, telegram, viber, Instagram, whatsapp ...) хэрэглэгчдийг хамгаалах, хуурамч хаяг хэрэглэгчдийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт, үр дүн:

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-mongolia.mn”-д хүүхэд хамгааллын “EKids” цонхыг хөгжүүлэн, үндэсний хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус системээр дамжуулан цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэдээ мэдээлэл, зөвлөмж зааварчилгаа, видео контент, постер, судалгааны тайлан, сургалтын гарын авлага зэргийг олон нийтэд хүргэхээс гадна эцэг, эх, асран хамгаалагч нар тус цонхыг ашиглан хүүхдийнхээ байршлыг хянах, чатлах, аюулгүй байдлыг хангах, хүүхдүүд шаардлагатай нөхцөл байдал үүсэхэд 101, 102, 103, 105 гэх мэт яаралтай тусламжийн дугаар луу шууд залгах боломжтой болсон. 2025 оны байдлаар “EKids” системд 32,247 хүүхэд бүртгүүлж, 59,718 удаа нэвтэрч, үйлчилгээ аваад байна. /www.ekids.mn/

Хүүхдийг цахим орчин дахь зохисгүй агуулга бүхий мэдээ, мэдээллээс хамгаалах, дэлгэцийн донтолт болон цахим орчинд үйлдэгдэж болох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Google Family Link” аппликэйшнийг монгол хэл рүү хөрвүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус аппликэйшнээр дамжуулан хүүхдийн дэлгэцийн цагийн хязгаарыг тохируулах, аппликэйшнг удирдах, ухаалаг төхөөрөмжийн байршлыг хянах, Google search ашиглан аюулгүйн хайлт хийх, “Youtube” дээр хяналтын тохиргоо хийх гэх мэт боломжтой.

“YouTube” платформтой хамтран хууль бус контентыг “trusted partner” горимоор мэдээлэх ажлыг 2021 оны 5 дугаар сараас эхлэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос хариуцсан ажиллаж байгаа бөгөөд дараах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч байна:

1. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн бүхий зураг, бичлэгийг цахим орчноос устгах IWF системд 2024 оны байдлаар Монгол Улсаас 44 хүсэлт явуулснаас уг агуулгад хамаарах 2 мэдээллийг цахим орчноос устгасан;
2. “Мета” компанитай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд “Green channel” буюу шууд харилцах ногоон сувгаар дамжуулан хүүхдэд сөрөг нөлөөтэй, хүүхдийн эрхийг зөрчсөн агуулгатай 30 хүсэлтээр 246 контент устгуулахаар явуулснаас 115 контентыг устгасан;
3. “Алфабет” компанийн хамтын ажиллагааны хүрээнд тус YouTube, Google drive зэрэг платформ дахь хүүхэд сөрөг нөлөөлтэй контентыг хязгаарлах, утгах хүсэлтийг уламжилж байна. 2024 онд 10 гомдол ирүүлснийг Google компанид уламжилж шийдвэрлүүлсэн байна.

Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхэд, залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан контентоос урьдчилан сэргийлэх зорилгоор IPTV, интернэтийн үйлчилгээнд эцэг эхийн хяналтын тохиргооны функцийг Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн

төлөөлөл /Монгол сат, ДДИШ, Юнивишн/-тэй хамтран нэвтрүүлсэн. Энэ үйлчилгээ нь хүүхдийн профайлаараа зөвхөн зөвшөөрөгдсөн суваг, кино контентыг үзэх боломжтой болсон.

Цахим орчинд тохиолдож болох эрсдэлийн тухай мэдлэг, ойлголт олгох, цахим орчны зохистой хэрэглээг хүүхэд, залуучууд төдийгүй нийгэмд сурталчлан таниулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. 2022 онд "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулган"-нд хүүхдийн насны ангиллын үндэсний стандартыг цахим сүлжээ болон өргөн нэвтрүүлэг, контентын орчинд нэвтрүүлэн, хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал" сэдэвтэй танилцуулга, шторк, видео бичлэгийг боловсруулан, олон нийтэд түгээсэн.
2. 2022 онд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио телевизийн хөтөлбөрийн дүрмийг таниулах зорилготой шторк бэлтгэн өргөн нэвтрүүлгийн телевиз радиогоор түгээсэн.
3. 2022 онд цахим аюулгүй байдал, хувийн нууцлал, эерэг харилцаа, шүүмжлэлт сэтгэлгээ болон худал мэдээллийг хэрхэн таних зэрэг сэдвүүдийг багтаасан 8 модуль бүхий хичээлийг "We Think Digital - Бид Цахим Иргэд" хөтөлбөрийн хүрээнд боловсруулж, 10 мянга гаруй иргэдэд түгээж, дунд сургуулийн 1 мянга орчим багш нарыг гарган, 40 сургагч багшийг бэлдсэн.
4. "ЮНЕСКО"-оос жил бүрийн аравдугаар сарын сүүлийн долоо хоногийг Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын долоо хоног болгон зарласан. Үүнтэй холбогдуулан 2022 онд хүүхэд, залуучуудын дунд мэдээлэлтэй зөв харилцах, худал мэдээллийг нягталж танин мэдэх чадварыг олгох, төрөл бүрийн арга хэлбэрээр контент бүтээх "Хакатон" тэмцээнийг зохион байгуулан, үр дүнг олон нийтэд түгээсэн.
5. 2023 оноос эхлэн "Цахим аюулгүй байдлын "Санго"-той хамтдаа" цуврал видео контент, зөвлөмж, гарын авлагыг монгол хэл дээр бэлтгэн гаргасан.
6. 2023 онд өсвөр үеийнхэнд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх мэдлэг олгох, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, нийгмийн сүлжээний олон талт асуудлыг судалж, өөрийн болон бусдын үзэл бодлыг хүндэтгэн үзэл бодлоо чөлөөтэй, нээлттэй илэрхийлэх, багаар хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготой "Цахим орчин-Хүүхдийн эрх" сэдэвт мэтгэлцээний улсын аварга шалгаруулах VIII тэмцээнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын Карл Попперын мэтгэлцээний нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан. Мэтгэлцээний финалын шатны 4 тоглолтоор контент бүтээж, МҮОНРТ-ын 1-р сувагаар олон нийтийн хүртээл болгон гаргасан.
7. 2023 онд Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагаас цахим аюулгүй байдлын чиглэлээр гаргасан гарын авлага, удирдамжийг шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, бизнесийн салбар, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулах "Цахим аюулгүй байдал" семинарыг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан.
8. 2023, 2024 онд цахим орчин дахь дээрэлхэлт, гадуурхалтай тэмцэх, өсвөр насны хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх "Найз байя" үндэсний нөлөөллийн аяныг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Дэлхийн зөн Олон Улсын Байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлсэн.

9. 2024 онд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаар мэдлэг ойлголт өгөх хоёр цуврал бүхий 3D хүүхэлдэйн кино /10 минут/ контентыг бүтээж, цахим орчинд түгээсэн.
10. Жил бүр: Мэдээллийн технологийн салбарт манлайлагч эмэгтэйчүүдээр дамжуулан охидод зөв үлгэр дуурайлал үзүүлэх, салбарын хүний нөөцийн жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн Улаанбаатар хот, 21 аймаг, 9 дүүргийн охидын 500 гаруй төлөөллийг хамарсан "Мэдээлэл, технологийн салбар дахь охидын манлайлал" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгт арга хэмжээг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран зохион байгуулсан. Мөн мэдээллийн технологийн салбарт охидын оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшүүлэх, дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн охидод мэдээлэл технологийн салбарын мэргэжил, онцлог, давуу талын талаар ойлголт мэдээлэл өгөх, цахим орчинд эрхээ хэрхэн хамгаалах асуудлын хүрээнд охидын өдрийг "Digital skills for life" уриалгын дор Харилцаа холбооны зохицуулах хороо, "Woman Techmakers Mongolia" байгууллагатай хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.
11. Цахим орчинд хүний эрх болон хүүхдийн эрхийг хамгаалах, иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, залилах /цахим/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор "Цахим орчинд хүний эрхийг хамгаалъя-Залилагчид боломж бүү олго" аяныг Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газартай хамтран зохион байгуулсан. Тус аяны хүрээнд цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, нийгмийн сүлжээнд хүүхдийн эрхийг хамгаалах, цахим аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх чиглэлээр нийт 77 мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн. Үүнд: телевизийн мэдээ 11 (*Монголын Үндэсний радио телевиз, Egale, Tenger, TV25, TV9, ETV, C1*) цахим хуудсаар дамжуулсан видео мэдээ 17 (*Зөвий.mn, Цахиур.mn, Товч.mn, Arslan.mn Unuudur.mn, UBN.mn, Peak.mn* зэрэг), нийтлэл 9, ярилцлага 4 (*өнөөдөр сонин, радио, FM: 88.3, 95.1, 103.6*), зорилтот видео 6, постер 30/
12. Олон нийтийн сүлжээн дэх худал мэдээлэл, хуурамч хаягийг таних болон цахим аюулгүй байдлаа хангах чиглэлээр зааварчилга, зөвлөмжийг мэргэжлийн эмч, хуульч, зөвлөхүүдтэй хамтран Paid media контент хэлбэрээр 21, "Reels" хэлбэрээр 10 буюу нийт 31 контентыг тус тус бэлтгэн, яамны цахим хуудас, нийгмийн сүлжээ, болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд түгээсэн. Тус арга хэмжээг идэвхжүүлэх зорилгоор "Цахим залилан" сэдэвт энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг нэг сарын хугацаатай "Зариг.мн" сайт, Баянгол дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлтэй хамтран зохион байгуулж, видео 10, зурагт хуудас 20, бусад мэдээ, мэдээлэл бэлтгэн хамтран түгээж, ажилласан. Олон нийтийн цахим сүлжээнд бэлтгэн байршуулсан мэдээ, мэдээлэл нь давхардсан тоогоор 20,104,319 хүнд хүрч, 108,832 хүнд таалагдаж, 12,649 хүн сэтгэгдэл үлдээж, 340,624 хүн бусадтай хуваалцаж, нийт санал, сэтгэгдлийн 86.4 % нь дэмжсэн, 4.1% нь шүүмжилсэн, 9.5% нь бусад сэтгэгдлүүд байна. Уг мэдээ, мэдээллийг 5,361,299 удаа хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний хувийн нийгмийн сүлжээ болон байгууллагын цахим хуудаст давхар нийтэлж, 25,465,618 хандалтыг авсан.

3. Хууль бус цахим бооцоот тоглоомын үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн.

Монгол Улсын хууль, тогтоомжийг зөрчсөн агуулгатай контентыг нийтэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр веб сайтыг хар жагсаалт (<http://black-list.mn>)-д оруулж, DNS системийн бүртгэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авч ажилладаг ба 2024 онд цахим орчин дахь хүүхэд хамгаалалтай холбоотой 436 веб сайтыг уг жагсаалтад оруулсан статистик мэдээлэл бүртгэгдсэн.

Цахим орчны зохисгүй хэрэглээ, хориотой, хууль бус контенттой холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох төрийн эрх бүхий байгууллагад шилжүүлж, хууль зөрчсөн эсэхийг тогтоолгох, тогтоогдсон нөхцөлд шийдвэрийн дагуу тухайн контентыг устгах, хязгаарлах талаар арга хэмжээг авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах <http://report.crc.gov.mn> системийг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс нэвтрүүлэн, байнгын тасралтгүй ажиллагаа Харилцаа холбооны зохицуулах хороо хариуцан ажиллаж байна.

---o0o---